



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 300

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.2.5 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, төвлөрүүлэх, өр төлбөрийг бүртгэх тайлагнах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "тайлан, мэдээлэл хүлээн авах, тайлагнах маягтууд"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулж Сангийн сайдын 2015 оны 227 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газар /Б.Гантулга/-т, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Б.БОЛОР

000707

**ӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ,  
МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ТӨВЛӨРҮҮЛЭХ,  
ӨР ТӨЛБӨРИЙГ БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь өрийн хэрэгслээр үүсгэсэн аливаа Засгийн газрын гадаад, дотоод зээллэг, Засгийн газрын гаргасан өрийн баталгаа, концессын гэрээний дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй үүссэн өр, аймаг, нийслэлийн гадаад, дотоод зээллэг, төрийн өмчит болон тэдгээрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр, төлбөрийн бүртгэлийг өрийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн сан” гэх)-д бүртгэх, өртэй холбоотой мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулан авах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд ашигласан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “өр” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.1-т заасныг;

1.2.2. “өрийн хэрэгсэл” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

1.2.3. “өрийн удирдлагын нэгж” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 9.2-т заасныг;

1.2.4. “Засгийн газрын өр” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг;

1.2.5. “өрийн улирлын тойм” гэж Засгийн газрын өрийн үлдэгдэл, эргэн төлөлт, ашиглалтын талаарх мэдээллийг агуулсан улирал тутам нэгтгэн гаргах статистик мэдээлэл, түүний танилцуулгыг;

1.2.6. “гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн жилийн тайлан” гэж гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг агуулсан нэгдсэн танилцуулгыг;

**Хоёр. Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх**

2.1. Өрийн удирдлагын нэгж нь мэдээллийн санд мэдээлэл бүртгэх, хөтлөх, шинэчлэх, мэдээллийн нэгдсэн сангаас хууль, эрх зүйн актад заасан мэдээллийг тархаах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

2.2. Мэдээллийн санд Өрийн удирдлагын тухай хуулийн 39.2-т заасан мэдээллийг төвлөрүүлнэ.

2.3. Мэдээллийн сан нь дараах зүйлээс бүрдэнэ:

2.3.1. Мэдээллийн бүртгэлийн систем:

2.3.1.1. Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (DMFAS);

2.3.1.2. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, удирдлагын мэдээллийн нэгдсэн сан (ODAMIS);

2.3.1.3. Бүртгэл, мэдээллийн бусад систем;

2.3.2. Өртэй холбогдолтой мэдээлэл агуулсан бүх төрлийн файл;

2.3.3. Цаасан болон цахим хэлбэрээр хадгалсан архивын нэгж;

2.3.4. Өр үүсгэх шийдвэр, гэрээ, хэлцэл, ашиглалт гарсныг нотолсон мэдэгдэл, нэхэмжлэх, төлбөрийн баримт зэрэг өртэй холбогдолтой баримт бичгүүд;

2.4. Өрийн удирдлагын нэгж нь мэдээллийг мэдээллийн бүртгэлийн системд бүртгэхдээ зааврын дагуу холбогдох этгээдээс гаргуулан авч, бүртгэнэ.

2.5. Засгийн газрын өрийн статистикийг төгрөгөөр илэрхийлэх бөгөөд ангилахдаа хугацааны хувьд урт хугацаат (1 жил буюу түүнээс дээш хугацаатай), богино хугацаат (1 жил хүртэлх хугацаатай), хугацаагаар ангилагдаагүй гэж, зээлдэгчийн төрлөөс хамааруулан гадаад, дотоод гэж, валютын бүтцээс хамааруулан төгрөгөөр илэрхийлэгдсэн, гадаад валютаар илэрхийлэгдсэн гэж тус тус ангилна.

### **Гурав. Үүссэн өртэй холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээллийн санд бүртгэх**

3.1. Өрийн удирдлагын нэгж нь Өрийн удирдлагын тухай хуулийн 39.2-т заасан мэдээллийг 39.4-т заасан этгээдээс улирал бүрийн дараа сарын 20-ны өдрийн дотор гаргуулан авч, өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.

3.2. Энэхүү журмын 3.1-т зааснаас гадна Өрийн удирдлагын тухай хуулийн 39.4.8-д заасан холбогдох бусад дараах этгээд нь өрийн удирдлагын нэгжид дор дурдсан мэдээллийг улирал бүрийн дараа сарын 20-ны өдрийн дотор хүргүүлж, тулган баталгаажуулалт хийнэ:

3.2.1. Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй байгуулсан концессын гэрээгээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний тайлант хугацаанд гарсан санхүүжилтийг (ашиглалт) гүйцэтгэлийн тайлангийн хамт;

3.2.2. Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тухайн улиралд гарсан санхүүжилтийг буюу гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтын мэдээ, гүйцэтгэлийн тайланг;

3.2.3. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлсэн зээлдэгч нь зээлийн эргэн төлөлтийн тайланг;

3.2.4. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь хийсэн зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан, эргэн төлөлтийн тайлан, төлбөрийн чадварын байдлын талаарх мэдээллийг;

3.2.5. Төсвийн ерөнхийлөн захирагч нь гадаад зээлийн ашиглалт, дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн тайлан, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг;

3.2.6. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь тухайн улиралд шинээр үүсгэсэн өр, эргэн төлөлтийн мэдээг;

3.3. Энэхүү журмын 3.2.2-т заасан этгээд тайлант хугацаанд гарсан ашиглалтын мэдээ, гүйцэтгэлийн тайланг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

3.4. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч болон гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдэгч нь өрийн эргэн төлөлтийн талаарх мэдээллийг төлбөр төлсөн даруйд өрийн удирдлагын нэгжид мэдэгдэнэ.

3.5. Мэдээллийн санд энэхүү журмын 2.2-т заасан мэдээллийг бүртгэхдээ дараах мэдээллийг цуглуулна:

3.5.1. Улсын Их Хурал, Засгийн газраас өр үүсгэхтэй холбогдуулж гаргасан аливаа шийдвэр, эрх зүйн акт;

3.5.2. зээлдүүлэгч талтай байгуулсан ерөнхий хэлэлцээр, түүний хүрээнд байгуулсан холбогдох гэрээ, хэлцэл;

3.5.3. зээллэгийн ерөнхий нөхцөлүүд, зээллэгийн дүн, хийсэн зээллэгийн хэмжээ;

3.5.4. зээллэгийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэл (хүүгийн төлбөрийн хувь хэмжээ, үндсэн төлбөрийн дүн, эргэн төлөх хуваарь, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа, бусад төлбөрийн талаарх мэдээллүүд);

3.5.5. зээллэгийн ашиглалт, эргэн төлөлтийн гүйцэтгэл, үлдэгдлийн дүн;

3.5.6. зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний улирал тутмын тайлан, жилийн тайлан, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан;

3.5.7. бусад.

3.6. Засгийн газрын өр үүсгэсэн холбогдох байгууллага өрийг шинээр мэдээллийн санд бүртгүүлэхэд дараах зүйлсийг бүрдүүлж, өрийн удирдлагын нэгжид хүргүүлнэ:

3.6.1. Засгийн газрын өрийг бүртгэхийг хүссэн албан хүсэлт;

3.6.2. Өр үүсгэхтэй холбогдон гарсан шийдвэр, эрх зүйн актууд;

3.6.3. Энэхүү журмын 3.6.2-т заасан шийдвэрийн хүрээнд байгуулсан гэрээ, хэлцэл;

3.6.4. Зээллэгийн нөхцөл, ашиглалт, эргэн төлөлтийн хуваарь;

3.6.5. Бусад;

3.7. Засгийн газрын өрийн бүртгэлээс дараах тохиолдолд өрийг хасч болох бөгөөд өрийн мэдээллийн нэгдсэн сангаас хасахгүй:

3.7.1. Өр төлбөр бүрэн төлөгдөж дууссан;

3.7.2. Зээлдүүлэгч талаас өр төлбөрийг чөлөөлсөн;

3.7.3. Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг бүхий ерөнхий гэрээ, хэлцэл эрх бүхий байгууллагын гаргасан мэдэгдэлд үндэслэн хүчингүй болсонд тооцогдсон.

**Дөрөв. Мэдээллийн сангаас статистик мэдээлэл  
тархаах, холбогдох байгууллагад мэдээлэх,  
олон нийтэд хэвлэн нийтлэх**

4.1. Өрийн удирдлагын нэгжийн дарга нь өрийн талаар бусад эрх зүйн актад заасан мэдээллийг тархаах хуваарийг баталж, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

4.2. Өрийн удирдлагын нэгж нь улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны талаар жилд нэг удаа энэхүү журмын 4.1-д заасан хуваарийн дагуу олон нийтэд мэдээлнэ.

4.3. Бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу өрийн удирдлагын нэгж нь дор дурдсан мэдээллийг улирал тутам өрийн тойм хэлбэрээр гаргаж мэдээлэл авах эрхтэй байгууллагад энэхүү журмын 4.1-д заасан хуваарийн дагуу хүргүүлэх бөгөөд энэхүү тоймыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж болно:

4.3.1. Засгийн газрын гадаад өр:

- 4.3.1.1. Засгийн газрын зээлийн үлдэгдэл, ашигласан хэмжээ, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.3.1.2. Засгийн газрын гаргасан үнэт цаасны үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.3.1.3. бусад гадаад өрийн үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл.
- 4.3.2. Засгийн газрын дотоод өр:
  - 4.3.2.1. Засгийн газрын зээлийн үлдэгдэл, ашигласан хэмжээ, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл;
  - 4.3.2.2. Засгийн газрын гаргасан үнэт цаасны үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл;
  - 4.3.2.3. бусад дотоод өрийн үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл.
- 4.3.3. Засгийн газрын гаргасан өрийн баталгааны хэмжээ, үлдэгдэл, баталгаа гаргуулагчийн зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.3.4. бусад өрийн үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.3.5. Засгийн газрын өрийн үлдэгдлийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дүн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагын хэрэгжилт, тооцоолол;

#### **Тав. Бусад**

- 5.1. Өрийн удирдлагын нэгж нь Засгийн газрын өрийн үлдэгдлийг зээлдүүлэгч талтай жил бүрийн 1 дүгээр улиралд багтан тооцоо нийлж, тулган баталгаажуулна.
- 5.2. Өрийн удирдлагын нэгж нь энэхүү журмын 3.2.2-т заасан тайланд үндэслэн жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний нэгдсэн тайланг гаргах бөгөөд энэхүү тайланд гадаадын тусламж, техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, концессын гэрээний дагуу хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, гадаад үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний тайланг тусгаж болно.
- 5.3. Өрийн удирдлагын нэгж нь дараах мэдээллүүдийг жил бүр архивын нэгж үүсгэн, холбогдох газарт хүлээлгэн өгөхөөс гадна цахим архив үүсгэн хадгална:
  - 5.3.1. Засгийн газрын гадаад, дотоод зээллэгийн ерөнхий хэлэлцээр, зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт;
  - 5.3.2. Өрийн улирал тутмын тойм, жилийн тайлан;
  - 5.3.3. Засгийн газрын өрийн үйлчилгээ, хийсэн зээллэгийн ашиглалтын тайлан, баримтууд;
- 5.4. Хууль тогтоомжид заасны дагуу өрийн удирдлагын нэгж нь цахим хэлбэрээр өртэй холбогдолтой мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд бусад тохиолдолд өртэй холбогдолтой мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр мэдээлнэ.

Сангийн сайдын 2015 оны 11 сарын 2  
 өдрийн 30 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Маягт-1

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН СТАТИСТИК (ӨРИЙН БҮТЭЦ)

Огноо: 20... оны ... сарын ... өдөр

(өссөн дүнгээр, сая төгрөг)

№	Үзүүлэлт	20.. 1 улирал	20.. 2 улирал	20.. 3 улирал	20.. 4 улирал
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨРИЙН БҮТЦЭЭР) (I+II+III)</b>					
<b>I</b>	<b>Засгийн газрын гадаад өр (1+2)</b>	...	...	...	...
<b>1</b>	<b>Богино хугацаат:</b>	...	...	...	...
1.1	Үнэт цаас	...	...	...	...
1.2	Зээл	...	...	...	...
1.3	Харилцах болон хадгаламж	...	...	...	...
1.4	Бусад өр төлбөр	...	...	...	...
<b>2</b>	<b>Урт хугацаат:</b>	...	...	...	...
2.1	Үнэт цаас	...	...	...	...
2.2	Зээл	...	...	...	...
2.3	Харилцах болон хадгаламж	...	...	...	...
2.4	Бусад өр төлбөр	...	...	...	...
<b>II</b>	<b>Засгийн газрын дотоод өр (3+4)</b>	...	...	...	...
<b>3</b>	<b>Богино хугацаат:</b>	...	...	...	...
3.1	Үнэт цаас	...	...	...	...
3.2	Зээл	...	...	...	...
3.3	Харилцах болон хадгаламж	...	...	...	...
3.4	Бусад өр төлбөр	...	...	...	...
<b>4</b>	<b>Урт хугацаат:</b>	...	...	...	...
4.1	Үнэт цаас	...	...	...	...
4.2	Зээл	...	...	...	...
4.3	Харилцах болон хадгаламж	...	...	...	...
4.4	Бусад өр төлбөр	...	...	...	...
<b>III</b>	<b>Бусад өр төлбөр (хугацаагаар ангилаагүй)</b>	...	...	...	...
5.1	...	...	...	...	...
5.2	...	...	...	...	...
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ВАЛЮТААР) (I+II)</b>					
I	Төгрөг	...	...	...	...
II	Гадаад валют	...	...	...	...
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ЗЭЭЛДЭГЧЭЭР) (I+II)</b>					
I	Дотоодын зээлдэгчид төлөх өр	...	...	...	...
II	Гадаадын зээлдэгчид төлөх өр	...	...	...	...
Тэмдэглэл:					
1)...					

## ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТЫН МЭДЭЭ

Огноо: 20... оны ... улирал

(сая төгрөг)

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, төслийн нэр, код	Зээлдэгч	Ашиглалт (тайлант хугацаанд гарсан)	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл өссөн дүнгээр
1	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ 1	...	...	...	...
1.1	Төслийн нэр, код	...	...	...	...
1.2	...	...	...	...	...
1	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ 2	...	...	...	...
2.1	Төслийн нэр, код	...	...	...	...
2.2	...	...	...	...	...

Тэмдэглэл:

1) ...

**ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨХ КОНЦЕССЫН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ**

Огноо: 20... оны ... улирал

(сая төгрөг)

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, төслийн нэр, код	Хэрэгжүүлэгч байгууллага	ЗГ, УИХ-ын шийдвэр, дугаар	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо	Гэрээний нийт дүн	Гэрээний дагуу гарах ашиглалт			Ашиглалтын гүйцэтгэл (тайлант хугацааны)	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл өссөн дүнгээр	Төслийн гүйцэтгэлийн хувь
							20..	20..	20..				
1	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ 1					...			...	...	...		
1.1	Төслийн нэр, код	...				...			...	...	...		
1.2	...	...				...			...	...	...		
1	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ 2					...			...	...	...		
2.1	Төслийн нэр, код	...				...			...	...	...		
2.2	...	...				...			...	...	...		

Тэмдэглэл:

1) ...

**ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ  
БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЖ  
БАЙГАА ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР**

**“...” төслийн 20... оны .. улирлын гүйцэтгэлийн тайлан**

1. Төслийн нэр: ...
2. Зорилго: ...
3. Санхүүжүүлэгч: ...
4. Хэрэгжүүлэгч байгууллага: ...
5. Тайлант хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт: ... (тооцоо нийлсэн дүнгээр)
6. Төслийн гүйцэтгэлийн хувь: ...
7. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд:
  - a. ...
  - b. ...
  - c. ...
8. Цаашид төлөвлөсөн ажлууд:
  - a. ...
9. Тулгамдаж буй асуудлууд:
  - a. ...
10. Шийдвэрлэх арга зам: ...
11. Төслийг хэрэгжүүлэгчийн мэдээлэл:
  - a. Хаяг: ...
  - b. Холбоо барих утас: ...
  - c. И-мэйл хаяг: ...
  - d. Бусад